

“КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”

ХУРАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Үндэслэл:

Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын 5.2.6-д туссан “Баялаг бүтээгчдийг дэмжих багц бодлого, хуулийн төсөл”-ийг боловсруулах зорилтын хүрээнд “Төрөөс компанийн нийгмийн хариуцлагын талаар баримтлах бодлого”-г боловсруулахаар Үндэсний хөгжлийн газар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Энэхүү бодлогын баримт бичгийн хүрээнд Компанийн нийгмийн хариуцлагыг бий болгоход оролцогч талуудын тал бүрийн оролцоог хангах шаардлагатай байгаа юм. Үүнд:

- Төрийн зүгээс тухайн салбарт Компанийн нийгмийн хариуцлагын талаар баримтлах бодлоготой болж хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Бизнесийн байгууллагууд өөрсдөдөө Компанийн нийгмийн хариуцлагын бодлогын баримт бичиг, баримтлах бодлоготой болох;
- Мэргэжлийн институт нь төр-хувийн хэвшлийн оролцоог зохистой түвшинд уялдуулсан бизнесийн шударга өрсөлдөөнийг бий болгох,
- Олон нийтийн байгууллага нь иргэд, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зэргээр олон талт оролцоо бизнесийн тогтвортой байдлыг хангуулж улмаар эрүүл орчинг бүрдээд оршино.

Зорилго:

Компанийн нийгмийн хариуцлагын талаар баримтлах бодлого боловсруулахад төр, хувийн хэвшил, мэргэжлийн институт, олон нийтийн байгууллагын оролцоог бий болгож тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлох, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжилтийг хангуулах зорилгоор хэлэлцүүлэг хийнэ.

Зорилт:

1. Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч оролцогч талуудын нийгмийн хариуцлагын чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ололт, түршлагыг хуваалцах;
2. Төрөөс Компанийн нийгмийн хариуцлагын талаар баримтлах бодлого боловсруулахад оролцогч талуудын саналыг тусгах;
3. Компанийн нийгмийн хариуцлагыг бодитой хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засаг болон нийгмийн орчинг бүрдүүлэх;

Зохион байгуулагч:

- Үндэсний Хөгжлийн Газар
- Конрад-Аденауэр-Сан
- Компанийн Засаглалын Үндэсний Зөвлөл

2018 оны 11 сарын 29-ны Пүрэв гаригт 15:00 цагт

Байршил: Централ Тауэр “МОНЕТ” ресторан

Мэдээллийн ивээн тэтгэгч:



Бүртгэл: 9009-7272

“КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО” ХУРАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГИЙН ХӨТӨЛБӨР

Нээлтийн үг:

1. **Б.Баярсайхан** / Үндэсний хөгжлийн газрын Дарга / 15:00-15:15
2. **Йоханн Фурманн** / Конрад-Аденауэр-Сангийн Суурин төлөөлөгч /

Илтгэл 1. /Төр ба компаниуд/:

1. **“Монгол улсын хөгжилд компанийн нийгмийн хариуцлагын гүйцэтгэх үүрэг” - А.Мөнхболд** /Үндэсний хөгжлийн газрын Судалгаа, шинжилгээний албаны Дарга/ 15:15-15:30
2. **“Мобиком корпорацийн КнХ-ийн баримтлах үндсэн чиглэл, төсөл хөтөлбөрүүд” - С.Дорждэрэм** /Мобиком корпорацийн Бодлого зохицуулалтын албаны Захирал/ 15:30-15:45
3. **“Компанийн нийгмийн хариуцлага - олон талт оролцоо” - Ш.Байгалмаа** /Оюутолгой ХХК-ийн Орон нутгийн харилцаа хариуцсан Захирал/ 15:45-16:00
4. **“Нийгмийн хариуцлага буюу ажилчиддаа хувьцаа эзэмшүүлэх замаар хувь эзэн болгох” - С.Халиунаа** /Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хууль дүрмийн хэрэгжилт хариуцсан Захирал/ 16:00-16:15
5. **Хэлэлцүүлэг, зөвлөмж** 16:15-16:30

ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА

Илтгэл 2. /Мэргэжлийн ба олон нийтийн байгууллага/:

1. **“Ажил олгогчийн Нийгмийн өмнө хүлээх хариуцлага” - Х. Ганбаатар** /Монголын ажил олгогч ээдийн нэгдсэн холбооны Дэд Ерөнхийлөгч/ 16:45-17:00
2. **“Компанийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд олон нийтийн оролцоо” - Д.Энхбат** /Иргэний нийгмийн хяналтын төвийн УЗ-ийн гишүүн/ 17:00-17:15
3. **“Төрөөс компанийн нийгмийн хариуцлагын талаар бодлого боловсруулахад анхаарах асуудал” - Д.Ганбаяр** /Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн Дарга/ 17:15-17:30
4. **Хэлэлцүүлэг, зөвлөмж** 17:30-18:00

ОРОЙН ХООЛ

ХҮЛЭЭН АВАЛТ: Networking – арга хэмжээ

18:00-19:00

19:00-21:00

Илтгэлүүдийг <http://www.governance.mn/file/71> линкээр орж татаж авна үү!

